



ТӨРИЙН ХЭЛНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА  
Ж.НЭРГҮЙ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.01 № 2/24 ЧАТ-САТ/2014 /СДИ/ДА-ДМЗ

Албан шаардлага хүргүүлэх тухай

Төрийн хэлний зөвлөлийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2013 онд 5 ажилтанд 31,181,772 төгрөгийн цалин хөлс тооцож, цалин хөлснөөс ХХОАТ-т 2,522,994 төгрөг суутган тооцож тайлагнах байтал 222,124 төгрөг суутган тооцож тайлагнан 2,300,870 төгрөгийн татвар дутуу суутгасан нь “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Ерөнхий аудиторын 2009 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсгийн заалтуудыг тус тус үндэслэн ШААРДАХ Нь:

Суутган тооцсон 2,300,870 төгрөгийг Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн Улаанбаатар банк дахь 2611017075 тоот дансанд, 2014 оны 6 дугаар сарын 1-ны өдрийн дотор тушаан зөрчлийг арилгах.

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн хэлний зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Нэргүй, нягтлан бодогч Г. Ганболд нарт хариуцуулав.

